



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/468

Арвайхээр

**Дуудлага худалдаа зохион байгуулах  
тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагуудаас ирсэн санал, Монгол санхүү бүртгэл ХХК-ийн үндсэн хөрөнгийн үнэлгээний тайлангийн дагуу Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын 440 хүүхдийн хичээлийн байрны барилгыг 2000 м.кв газрын хамт 5,053,951,23 (таван сая тавин гурван мянга есөн зуун тавин нэгэн төгрөг хорин гурван мөнгө), Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газрын Зочид буудлын барилгыг 250 м<sup>2</sup> газрын хамт 603,190,18 (зургаан зуун гурван мянга нэг зуун ерэн төгрөг арван найман мөнгө), Соёлын төвийн хуучин барилгыг 400 м<sup>2</sup> газрын хамт 1,085,672,34 (нэг сая наян таван мянга зургаан зуун далан хоёр төгрөг гучин дөрвөн мөнгө), Хархорин сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33,712,000 (гучин гурван сая долоон зуун арван хоёр мянга) төгрөгийн үнэ бүхий 2408 м<sup>2</sup> газрыг тус тус дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдааг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсугай.

3. Хөрөнгийн дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданям)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100993

D:My Doc. Zahiramj. Zasag darga